



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 8/67

Улаанбаатар хот

**Дүүргийн Гамшгаас хамгаалах
төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэг, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Заавар батлах тухай” 120 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангуулах, гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, болзошгүй гамшгийн үед хариу арга хэмжээг шуурхай авах, уялдаа холбоотой ажиллах “Дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийг нэгдүгээр, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө шинэчлэн боловсруулах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2026 оны 02 дугаар улиралд багтаан батлуулах, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, салбар хоорондын харилцан ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Г.Дагвадорж)-т үүрэг болгосугай.

3.Дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө шинэчлэн боловсруулахад шаардагдах 1,007,000 (Нэг сая долоон мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 16-ны өдрийн
1167 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ДҮҮРГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЧЛЭН
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: - Дүүргийн менежер
- Гишүүд: - Засаг даргын Тамгын газрын дарга
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Онцгой байдлын хэлтсийн дарга
- Цагдаагийн хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн төвийн дарга
- 1 дүгээр хорооны Засаг дарга
- 2 дугаар хорооны Засаг дарга
- Нарийн бичгийн дарга: Засаг даргын тамгын газрын холбогдох мэргэжилтэн болон Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 4 дугаар сарын 11 -ны өдрийн
4167 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ДҮҮРГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЧЛЭН
БОЛОВСРУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн:	Тайлбар
Нэг. Бичиг хэргийн материал						
1	Бичгийн цаас	боодол	3	22,000	66,000	2026 оны гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний тайланг тус бүр 3 хувь хэвлэх, баталгаажуулах
2	Принтерийн хор /өнгөт/	ширхэг	8	7,000	56,000	
3	Дөрвөлжин нуруу /5 см, 3 см/	ширхэг	10	1,500	15,000	
4	Архивын цаас	боодол	1	200,000	200,000	
5	Фото цаас	боодол	2	20,000	40,000	
6	Слайд	боодол	1	30,000	30,000	
7	Бусад жижиг хэрэгсэл	ком	1	100,000	100,000	
Дүн:					407,000	
Хоёр. Хоол хүнсний зардал						
8	Хоол хүнс	20 алба хаагч	1 өдөр ажиллах	нэг өдрийн хоолны мөнгө 30,000 төгрөг	600,000	Нэг өдөр Онцгой байдлын хэлтсийн сургалтын танхимд ажиллана.
НИЙТ ДҮН:					1,007,000	